



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 15 өдөр

Дугаар А/23

Мандалговь

Мотоциклын хөдөлгөөнийг түр
хориглох тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 в, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.2, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Хүйтэрч, халтиргаа гулгаа үүсч байгаатай холбогдуулан Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган болзошгүй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн хэмжээнд мотоциклтой замын хөдөлгөөнд оролцохыг 2021 оны 01 дүгээр сарын 14-ний өдрөөс 2021 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд түр хориглосугай.

Хоёр. Аймгийн хэмжээнд мотоциклын хөдөлгөөнийг түр хугацаагаар хориглосонтой холбогдуулан замын хөдөлгөөнд хяналт тавьж, илэрсэн зөрчилд хариуцлага тооцож ажиллахыг Цагдаагийн газар (Г.Наранбаатар)-т үүрэг болгосугай.

Гурав. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль, эрх зүйн хэлтэс (Б.Түвшинбаяр), сумдын Засаг дарга нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

481213047